

ЗӨВШӨӨРСӨН.  
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ  
ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  
*Ц. Зүрэгбилэг* Ц.ЭРДЭМБИЛЭГ

БАТЛАВ.  
ЭРҮҮЛ МОНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ  
СЭРГЭЭН ЗАСАЛ МЭРГЭЖЛИЙН  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  
*А. Балжинням* А.БАЛЖИННЯМ

ХҮНИЙ ИХ ЭМЧИЙН  
“СЭРГЭЭН ЗАСАХ СУДЛАЛ” ҮНДСЭН  
МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Мэргэжлийн индекс: S(r) 091501  
Суралцах хугацаа: 2 жил

Улаанбаатар  
2022

## **БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ:**

- А.Балжинням Анагаахын шинжлэх ухааны их сургуулийн Сэргээн засах анагаах ухааны тэнхимийн эрхлэгч, Анагаах ухааны доктор, дэд профессор, зөвлөх зэргийн эмч,
- Ш.Батчимэг Анагаахын шинжлэх ухааны их сургуулийн Сэргээн засах анагаах ухааны тэнхимийн багш, Анагаах ухааны доктор, тэргүүлэх зэргийн эмч,

### **Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн төлөөлөл:**

- Ц.Наранцэцэг Анагаахын шинжлэх ухааны их сургуулийн Сэргээн засах анагаах ухааны тэнхимийн багш, Анагаах ухааны магистр, тэргүүлэх зэргийн эмч,

### **Эрүүл мэндийн байгууллагын төлөөлөл:**

- С.Дэлгэрмаа Улсын гуравдугаар төв эмнэлгийн Сэргээн засах эмчилгээний тасгийн эрхлэгч, Анагаах ухааны магистр клиникийн профессор, зөвлөх зэргийн эмч,
- Ж.Соёлмаа Мөнгөн гүүр эмнэлгийн Сэргээн засах эмчилгээний тасгийн эрхлэгч, Анагаах ухааны магистр, клиникийн профессор, тэргүүлэх зэргийн эмч,
- Б.Даваажав Улсын гуравдугаар төв эмнэлгийн Сэргээн засах эмчилгээний тасгийн эмч, Анагаах ухааны магистр, тэргүүлэх зэргийн эмч,

## **ХЯНАСАН:**

- П.Эрхэмбаяр Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Нийгмийн эрүүл мэндийн магистр;
- Б.Туяа Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Салбарын хүний нөөцийн мэргэшил, сургалт, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн;
- Д.Дондогмаа Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны ахлах мэргэжилтэн, Анагаах ухааны магистр;

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн  
зөвлөлийн 2022 оны 09 дүгээр сарын 09-ний  
өдрийн 15 дугаар тогтоолоор зөвшөөрөв.

## ХҮНИЙ ИХ ЭМЧИЙН “СЭРГЭЭН ЗАСАХ СУДЛАЛ” ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

### НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Эрдэмтдийн судалгаагаар дэлхийн хүн амын дундаж наслалт ихсэж, халдварт бус архаг өвчний тохиолдол нэмэгдэж, эрүүл мэндийн салбарт ихээхэн дарамт болж байгаас эрүүл мэндийн салбарын хөгжлийн чиг хандлага өөрчлөгдөж байна.

Насжилт, халдварт бус өвчлөлийн улмаас хүмүүс нэг болон түүнээс дээш тооны үйл ажиллагааны хязгаарлалттай амьдарч энэ нь чадвар алдагдалд хүргэх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Халдварт бус өвчлөл нь насжилт болон үйл ажиллагааны хязгаарлалттай хавсарч байгаа үед урт хугацааны мэдрэхүй, танин мэдэхүй, хөдөлгөөний, өдөр тутмын үйл ажиллагааны чадварууд алдагддаг. Иймд эрт нас барах тохиолдлоос илүүтэйгээр чадвар алдагдалтай болох магадлал илүү байдаг.

Сэргээн засах эмчилгээ нь үйл ажиллагааны чадварыг сэргээх, чадвар алдагдалд хүргэж буй хүчин зүйлсийг бууруулах, хүндрэлээс сэргийлэх зорилгоор өвчтөний өвдөж эхэлсэн үеэс эхэлж, юу хүсэж байгаа хүртэл урт хугацаанд хийгдэх бөгөөд хүний амьдралын чанарыг дээшлүүлэх эрүүл мэндийн салбарын бүрэлдэхүүн хэсэг билээ. XXI зууны эрүүл мэндийн стратегийн гол түлхүүр нь сэргээн засах эмчилгээ болон туслах хэрэгсэл болж байна гэдгийг ДЭМБ онцлон тэмдэглэсээр байна.

Сүүлийн жилүүдэд Монголд төдийгүй дэлхий дахинаа халдварт бус өвчлөлийн тоо болон хүн амын дундаж наслалт нэмэгдснээр чадвар алдагдалтай, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо ихсэх хандлагатай байгаа тул хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд тулгуурласан сэргээн засахын үндсэн мэргэжлийн тусламж үзүүлэх чадвартай эмч бэлтгэх зайлшгүй шаардлагатай байна.

### ХОЁР. ЭРХЭМ ЗОРИЛГО

Зонхилон тохиолдох өвчин эмгэгийн сэргээн засах оношилгоо, эмчилгээний тусламж үйлчилгээг эрүүл мэндийн бүх шатлалд бие-сэтгэц-нийгмийн загвараар үзүүлэх чадвартай сэргээн засалч их эмч бэлтгэхэд оршино.

### ГУРАВ. АЛСЫН ХАРАА

**Сэргээн засал судлалын сургалтын хөтөлбөрөөр бэлтгэх эмчийн дүр зураг:**

Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх үүрэг хариуцлагаа бүрэн ойлгосон; сэргээн засах анагаах ухааны зонхилон тохиолдох өвчний оношилгоо, эмчилгээ хийхэд шаардагдах мэдлэг, ур чадварыг эзэмшсэн; өвчтөнд энэрэх сэтгэлээр хандаж, эмчийн ёс зүйг чандлан баримталдаг, багаар ажиллан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үр дүнтэй үзүүлж чаддаг эмч байна.

## ДӨРӨВ. “СЭРГЭЭН ЗАСАХ АНАГААХ УХААН СУДЛАЛ”-ЫН ЭМЧИЙН ЦӨМ ЧАДАМЖ

Алсын харааг хэрэгжүүлэхэд чиглэсэн дор дурдсан цөм чадамжийг эзэмшсэн байна.

1. Сэргээн засахын эмч (*Rehabilitation doctor*)
2. Мэргэжлийн байх (*Professional*)
3. Суралцагч (*Learner*)
4. Харилцагч (*Communicator*)
5. Хамтрагч (*Collaborator*)
6. Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч (*Community health advocate*)
7. Зохион байгуулагч, манлайлагч (*leader*)

### ТАВ. СУРГАЛТЫН ЗОРИЛТ

Цөм чадамж бүхий эмч болохын тулд дор дурдсан чадамжийг эзэмшиж, бие даан гүйцэтгэж чаддаг болно. Үүнд:

#### 1. Сэргээн засахын эмч (*Rehabilitation doctor*):

- Зонхилон тохиолдох өвчин эмгэгийн сэргээн засалч эмчийн тусламж үйлчилгээг бие-сэтгэц-нийгмийн загвараар үзүүлэх;
  - Тухайн хүнд хадгалагдаж үлдсэн болон алдагдсан чадварыг илрүүлэх, анамнез авах, оношлох, үзлэг хийх, асуудлыг тодорхойлох;
  - Эрсдэлт хүчин зүйл болон чадвар алдагдал, нийгмийн оролцоо хязгаарлагдахад хүргэж буй шалтгааныг илрүүлэх;
  - Сэргээн засах эмчилгээний төлөвлөгөө боловсруулах, зорилго тодорхойлох;
  - Эмчилгээний явцад шинээр гарсан асуудлыг оношлох, эмчлэх;
  - Сэргээн засах эмчилгээний багаар ажиллах;
  - Эмийн болон тарилга эмчилгээ, дасгал хөдөлгөөн, туслах хэрэгсэл, дэмжих хэрэгслийн тусламжтай тусламж үйлчилгээ үзүүлэх;
  - Мэдрэл-булчингийн (ботокс, хориг), яс-булчингийн тарилгуудыг эмчийн хяналтад (мэдрэл, яс булчингийн хэт авиан хяналтанд үе, зөөлөн эдэд тарих, өвдөлт сэдээх цэгт хатгах, тарих, проло эмчилгээ гм) хийх;
  - Өвчний тавилан тодорхойлох;
  - Шаардлагатай тохиолдолд эмнэлгийн бусад мэргэжилтэнд үйлчлүүлэгчийг илгээх, хамтран ажиллах чадвар эзэмших;
  - Эрүүл мэндийн боловсрол олгох;
  - Ортез, протезийн үнэлгээ хийх;
  - Давсаг гэдэсний менежмент хийх;
  - Зүрх судасны үйл ажиллагааны үнэлгээ хийх;
  - Тархи, мэдрэлийн үйл ажиллагааны үнэлгээ хийх;
  - Хүүхдийн эмгэгийн үеийн үнэлгээ хийх;
  - Дотоод шүүрлийн үнэлгээ хийх;
1. Настны үнэлгээ хийх;
  2. Эмэгтэйчүүдийн үнэлгээ хийх;
  3. Хавдартай өвчтөнд үнэлгээ хийх;
  4. Үйлчлүүлэгчтэй харилцан ярилцах, анамнез цуглуулах;

5. Сэргээн засах эмчилгээний эмчийн үзлэгийг өвчтөнд тохируулан оновчтой хийх;
6. Урьдчилсан онош тавих, үндэслэл бичих;
7. Ялган оношлох өвчин, эмгэгийг жагсааж, нотлох шинжилгээ төлөвлөх, шинжилгээнд хэрхэн бэлтгэх талаар зөвлөх;
8. Эмнэлзүйн тохиолдлын хэлэлцүүлэг хийх;
9. Багажийн шинжилгээ (булчингийн цахилгаан бичлэг, рентген, КТГ, СРТ, уродинамика, видеофлюроскопи)-ний хариуг унших, дүгнэх;
10. Захын мэдрэл, яс-булчингийн хэт авиан шинжилгээг хийх;
11. Булчин чангарлын менежмент хийх (spasticity management);
12. Оношинд тохирсон эмчилгээ төлөвлөх, динамик ажиглалт хийж, дүгнэлт өгөх;
13. Үйлчлүүлэгч, ар гэрийнхэнд биеийн байдал, оношилгоо, эмчилгээний талаар тайлбарлах;
14. Өвчний сэдрэлээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгөх;
15. Үл ашиглах хамшинжээс сэргийлэх эмчилгээ хийх, зөвлөгөө өгөх.

## **2. Мэргэжлийн байх (Professional)**

- Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвд өөрийн мэргэшлээр хувь нэмэр оруулах хүсэл эрмэлзэлтэй байх;
- Өвчтөнийг хувь хүний хувьд хүндэтгэж, хамгийн оновчтой зөв шийдвэр гаргахын төлөө ажиллах;
- Хувь хүний онцлогийг харгалзан өвчтөн болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл садны хүмүүстэй хүндэтгэлтэй харьцах.

## **3. Суралцагч (Learner)**

- Сэргээн засах анагаах ухааны мэдлэг, ур чадвар, дээшлүүлэхийн тулд хэрэгцээт сургалтад тогтмол хамрагдах;
- Байнга шинэчлэгдэж байгаа анагаах ухааны дэвшлээс хоцрохгүйн тулд бие даан тасралтгүйгээр суралцах, олон төрлийн мэдээллийн эх үүсвэрийг судлах, дүн шинжилгээ хийх;
- Хамтран суралцагч эмч, бусад эмнэлгийн мэргэжилтэнд заах замаар өөрийн мэдлэг, ур чадвараа сайжруулах.

## **4. Харилцагч (Communicator)**

- Өвчтөн, түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл, садны хүмүүстэй зөв эелдэг харилцах;
- Өвчтөнд шаардлагатай мэдээлэл өгөхдөө ойлгоход хялбар үг, хэллэг ашиглан тайлбарлах;
- Шаардлагатай тохиолдолд өвчтөний оношилгоо, эмчилгээний талаар бусад эмнэлгийн мэргэжилтэнтэй зөвлөлдөх.

## **5. Хамтрагч (Collaborator)**

- Тухайн ажиллаж байгаа газартаа сэргээн засах анагаах ухааны эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой асуудлаар мэргэшлийн эмч нартай мэдээлэл солилцож, хамтран ажиллах;
- Эмнэлгийн бусад тасгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй мэргэжлийн мэдлэг, мэдээллээ хуваалцах, хамтран ажиллах.

#### **6. Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч (*Community health advocate*)**

- Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч байхын тулд зонхилон тохиолдох өвчнөөс сэргээн засах анагаах ухааны урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээ үзүүлэх, сургалт сурталчилгаа явуулах;
- Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд тохирсон сэргээн засах анагаах ухааны арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Үйлчлүүлэгч болон ар гэрийнхэн, асран хамгаалагчтай ярилцах;
- Дэмжих, зөвлөгөө өгөх;
- Хүний эрх болон эдлэх боломжийн тухай зөвлөх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх болон эдлэх боломжийн тухай зөвлөх;
- Эмчилгээний үр дүнг удаан хугацаанд хадгалах, үргэлжлүүлэх талаар зөвлөх.

#### **7. Зохион байгуулагч, манлайлагч (*leader*)**

- Хувь хүний болон байгууллагад тулгарсан шийдвэрлэх асуудлыг шийдвэрлэх;
- Сэргээн засах эмчилгээний багийг удирдах;
- Сэргээн засах тусламж үйлчилгээтэй холбоотой асуудалд хяналт, үнэлгээ хийх, тайлагнах;
- Чадвар, үр дүнг баталгаажуулах;
- Сэргээн засах анагаах ухааны эрүүл мэндийн тусламж үйлчилгээг зохицуулах, манлайлан ажиллах үүргээ ухамсарлах;
- Эмнэлэг, эрүүл мэндийн төв дэх сэргээн засах анагаах ухааны тусламж үйлчилгээ үзүүлэх багийг манлайлан ажиллах үүргээ ухамсарлах.

### **ЗУРГАА. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ**

#### **6.1. Сургалтын чиглэл, хугацаа, байршил**

- Сургалтыг Үйл ажиллагааны анатоми, биомеханик, Ерөнхий сэргээн засах судлал (амьсгал, зүрх судас, настны сэргээн засах оношилгоо, эмчилгээ), Өвдөлтийн менежмент, Ортез, протез, Яс-булчингийн хэт авиа, булчингийн цахилгаан бичлэг, уродинамик, радиологи, Мэдрэлийн өвчний сэргээн засах оношилгоо, эмчилгээ, Хүүхдийн өвчний сэргээн засах оношилгоо, эмчилгээ, Гэмтлийн дараах сэргээн засах оношилгоо, эмчилгээ, Хавдрын сэргээн засах оношилгоо, эмчилгээ гэсэн 9 чиглэлээр тойролт хийж, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлага, Амилуулах суурь тусламж, Халдварын сэргийлэлт, хяналт, Эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль, журам, зөрчлийн тухай хууль, хувь хүний нууцтай холбоотой хууль, Эмнэлгийн эрх зүйн чиглэлээр сургалтанд заавал хамрагдана.
- Сургалтын хугацаа 2 жил байна.

- Сонгон суралцах чиглэлийг сургалт эрхлэх байгууллагаас гаргасан чиглэлээс сонгох ба сургалтын хугацаа нь 1 сараас доошгүй хугацаанд явагдана.
- Суралцагч эмчийн өдөр тутмын болон 7 хоногийн үйл ажиллагааны тодорхой хуваарийг сургалт эрхлэх байгууллагаас боловсруулна.
- Эмнэлзүйн мэргэшүүлэх сургалт эрхлэх байгууллагад тавигдах шаардлага хангаж, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлөөс “Сэргээн засах судлал” үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх зөвшөөрөл авсан эмнэлгийн тусламж үйлчилгээний байгууллага нь энэхүү сургалтын үндсэн байгууллага байна. Сургалтыг тойролт хэлбэрээр явуулах бөгөөд тойролтын хугацааг сургалтын сүлжээнд нэгдсэн эмнэлгүүдийн онцлог, хүчин чадалд нийцүүлэн сургалт эрхлэх үндсэн байгууллага төлөвлөн зохицуулна.

## **6.2. Зайлшгүй танин мэдэж, суралцах шаардлагатай шинж тэмдэг, өвчин, гардан үйлдэл:**

Сургалтын төгсгөлд эмнэлзүйн талбарт бие даан тусламж үйлчилгээ үзүүлэх ур чадвар, дадлага эзэмшихийн тулд эмнэлзүйн сургагч багшийн удирдлага дор амбулатороор болон хэвтэн эмчлүүлэх өвчтөнийг оношлох, эмчлэхдээ дор дурдсан шинж тэмдгээр гардан үйлдлийг гүйцэтгэж, туршлага хуримтлуулна.

### **6.2.1. Шинж тэмдэг (signs and symptoms) (аль ч тойролтод тохиолдох)**

Өвчний түүх, бодит үзлэгт үндэслэн эрэмбэлэн ангилж, ялган оношилгоо хийж, анхан шатны эмчилгээг эхлүүлж чаддаг болох:

1. Хүзүү, нурууны өвдөлт (neck and back pain)
2. Үений өвдөлт (arthralgia)
3. Зөөлөн эдийн өвдөлт (soft tissue pain)
4. Булчин хальс өвдөх хам шинж (myofascial pain syndrome)
5. Мэдрэлийн өвдөлт (neuropathic pain)
6. Мөчдийн саажилт (paralysis)
7. Биеийн төрх байдлын өөрчлөлт (changes in the body posture )
8. Алхааны өөрчлөлт (gait changes)
9. Амьсгаадалт (dyspnea)
10. Ханиалгалт (coughing)
11. Үл ашиглах хам шинж (deconditioning syndrome)
12. Өдөр тутмын үйл ажиллагааны алдагдал (impairment of activities of daily living)
13. Нийгмийн үйл ажиллагаа хязгаарлагдах (restriction social participation)
14. Хаван (edema)
15. Үений хөдөлгөөний далайц хязгаарлалт (contracture)
16. Булчингийн хүчний сулрал (muscle weakness)
17. Булчингийн хатангиршил (muscle atrophy)
18. Булчингийн тонусын өөрчлөлт (changes in muscle tone)
19. Мэдрэхүйн өөрчлөлт (changes in sensation)
20. Рефлексийн өөрчлөлт (changes of reflex)
21. Түлэгдэлт (burns)
22. Хөлдөлт (frostbite)

## 23. Үйл ажиллагааны чадвар алдалт (functional impairment)

### 6.2.2. Өвчин (тойролт тус бүрээр)

1. Өвчин тус бүрийг оношилж, эмчлэх, тусламж үзүүлж чаддаг болох;
2. Тусламж үйлчилгээ үзүүлэх явцад орон нутгийн эмнэлгээс дээд шатлалын эмнэлэгт өвчтөн шилжүүлэх заалтыг мэддэг болох;
3. Дээд шатлалын эмнэлэгт өвчтөнг аюулгүйгээр шилжүүлэх аргад суралцах;
4. Өвчтөн, түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл, садны хүнд өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг эрт үед нь илрүүлэх талаар зааж, зөвлөгөө өгөхөд суралцах.

#### *Мэдрэлийн өвчин:*

1. Тархины саа ба бусад саажилтын хамшинж (Cerebral palsy and others paralytic syndromes) (G80-G83)
2. Паркинсоны эмгэг (Parkinson`s disease) (G20)
3. Мэдрэл, мэдрэлийн ёзоор ба сүлжээний эмгэг (Nerve, nerve root and plexus disorders) (G50-59)
4. Полиневропати ба захын мэдрэлийн тогтолцооны бусад эмгэг (Polyneuropathies and other disorders of the peripheral nervous system) (G60-64)
5. Булчин-мэдрэлийн холбоос ба булчингийн эмгэг (Diseases of myoneural junction and muscle) (G70-73)
6. Нугасны бусад эмгэг (Other diseases of spinal cord) (G95)

#### *Зүрх судасны тогтолцооны өвчин:*

1. Хэрлэгийн гаралтай зүрхний архаг өвчнүүд (Chronic rheumatic heart diseases) (I05-09)
2. Зүрхний ишемит өвчин (Ischaemic heart diseases) (I20-25)
3. Тархины судасны өвчин (Cerebrovascular diseases) (I60-69)

#### *Амьсгалын тогтолцооны өвчин:*

1. Томуу ба пневмони (Influenza and pneumonia) (J09-18)
2. Амьсгалын дээд замын бусад өвчин (Other diseases of upper respiratory tract) (J30-39)
3. Амьсгалын доод замын архаг өвчин (Chronic lower respiratory diseases) (J40-47)

#### *Яс-булчингийн тогтолцоо ба холбох эдийн өвчин:*

1. Артропати (Arthropathies) (M00-25)
2. Холбох эдийн тогтолцоот эмгэгүүд (Systemic connective tissue disorders) (M30-36)
3. Дорсопати (Dorsopathies) (M40-54)
4. Зөөлөн эдийн эмгэгүүд (Soft tissue disorders) (M60-79)
5. Остеопати ба хондропати (Osteopathies and chondropathies) (M80-94)
6. Яс-булчингийн тогтолцоо ба холбох эдийн бусад эмгэг (Other disorders of the musculoskeletal system and connective tissue) (M95-M99)

7. Яс-булчингийн тогтолцооны төрөлх гажиг ба гаж хөгжил (Congenital malformations and deformations of the musculoskeletal system) (Q65-79)

*Гэмтэл судлал:*

1. Толгойн гэмтлүүд (Injuries to the head) (S00-09)
2. Нугасны гэмтэл (Spinal cord injury) (S14.109A)
3. Хүзүүний гэмтэл (Injuries to the neck) (S10-19)
4. Цээжний гэмтэл (Injuries to the thorax) (S20-29)
5. Хэвлий, зоо нуруу, ууц ба аарцгийн гэмтэл (Injuries to the abdomen, lower back, lumbar spine and pelvic) (S30-39)
6. Мөр ба бугалгын гэмтэл (Injuries to the shoulder and upper arm) (S40-49)
7. Тохой ба шууны гэмтэл (Injuries to the elbow and forearm) (S50-59)
8. Бугуй ба сарвууны гэмтэл (Injuries to the wrist and hand) (S60-69)
9. Түнх ба гуя орчмын гэмтэл (Injuries to the hip and thigh) (S70-79)
10. Өвдөг ба шилбэний гэмтэл (Injuries to the knee and lower leg) (S80-89)
11. Шагай ба тавхайн гэмтэл (Injuries to the ankle and foot) (S90-99)
12. Халууны ба химийн үйлчлэлээр түлэгдэх (Burns and corrosions) (T20-T32)
13. Хөлдөлт (Frostbite) (T33-35)

*Бусад эмгэгүүд:*

1. Чихрийн шижин (diabetes mellitus) (E08.9)
2. Лимфийн хаван (lymphedema) (I89.0)
3. Хөхний өмөн (breast cancer) (C50)
4. Эрхтэн шилжүүлэх мэс заслын дараах эмгэгүүд (transplanted organ) (Z94)
5. Үе солих хагалгааны дараах эмгэгүүд (aftercare following joint replacement surgery) (Z47)

**6.2.3. Гардан үйлдэл**

1. Үений хөдөлгөөний далайц үнэлэх (range of motion (ROM) assessment) (93.05)
2. Булчингийн хүч үнэлэх (manual muscle test (MMT) assessment) (93.04)
3. Өвдөлтийг үнэлэх (pain assessment (VAS) assessment)
4. Биеийн ачаалал даах чадварыг тодорхойлох (aerobic capacity assessment)
5. Өдөр тутмын үйл ажиллагааг үнэлэх (activities of daily living assessment)
6. Морфометрийн үнэлгээ хийх (morphometric analysis) (93.07)
7. Булчингийн тонус шалгах (muscle tone assessment)
8. Рефлекс үнэлэх (reflex assessment)
9. Мэдрэхүйг үнэлэх (sensation assessment)
10. Тэнцвэрийг үнэлэх (balance assessment)
11. Төрх байдлыг үнэлэх (posture assessment)
12. Алхааны үнэлгээ хийх (gait analysis) (93.22)
13. Өвөрмөц сорилуудаар үнэлэх (special test assessment)

### Тойролтын хуваарь

Д/д	Тойролтын нэр	Хугацаа /7 хоног/	Тойролт хийх газар
1.	Үйл ажиллагааны анатоми, биомеханик	8	Анагаахын шинжлэх ухааны их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн Сэргээн засах анагаах ухааны төв, Анагаахын шинжлэх ухааны их сургуулийн Анагаах ухааны сургуулийн сэргээн засах анагаах ухааны тэнхим
2.	Дотрын сэргээн засах оношилгоо, эмчилгээ (амьсгал, зүрх судас, настаны сэргээн засах)	12	Улсын нэгдүгээр, хоёрдугаар, гуравдугаар төв эмнэлгийн сэргээн засах тасаг, Геронтологийн үндэсний төв
3.	Өвдөлтийн менежмент	8	Анагаахын шинжлэх ухааны их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн Сэргээн засах анагаах ухааны төв, Анагаахын шинжлэх ухааны их сургуулийн Анагаах ухааны сургуулийн сэргээн засах анагаах ухааны тэнхим
4.	Ортоз, протез, туслах технологи	8	Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв
5.	Захын мэдрэл, яс-булчингийн хэт авиа, булчингийн цахилгаан бичлэг, уродинамик, радиологи	12	Анагаахын шинжлэх ухааны их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн Сэргээн засах анагаах ухааны төв, Анагаахын шинжлэх ухааны их сургуулийн Анагаах ухааны сургуулийн сэргээн засах анагаах ухааны тэнхим, Мөнгөн гүүр эмнэлгийн сэргээн засах тасаг, Анагаахын шинжлэх ухааны их сургуулийн Анагаах ухааны сургуулийн Радиологийн тэнхим
6.	Мэдрэлийн өвчний сэргээн засах оношилгоо, эмчилгээ	12	Анагаахын шинжлэх ухааны их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн Сэргээн засах анагаах ухааны төв, Анагаахын шинжлэх ухааны их

			сургуулийн Анагаах ухааны сургуулийн сэргээн засах анагаах ухааны тэнхим, Улсын нэгдүгээр, хоёрдугаар, гуравдугаар төв эмнэлгийн сэргээн засах тасаг
7.	Хүүхдийн өвчний сэргээн засах оношилгоо, эмчилгээ	12	Анагаахын шинжлэх ухааны их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн Сэргээн засах анагаах ухааны төв, Анагаахын шинжлэх ухааны их сургуулийн Анагаах ухааны сургуулийн сэргээн засах анагаах ухааны тэнхим, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн сэргээн засах тасаг, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв
8.	Гэмтлийн дараах сэргээн засах оношилгоо, эмчилгээ	12	Анагаахын шинжлэх ухааны их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн Сэргээн засах анагаах ухааны төв, Анагаахын шинжлэх ухааны их сургуулийн Анагаах ухааны сургуулийн сэргээн засах анагаах ухааны тэнхим, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Мөнгөн гүүр эмнэлгийн сэргээн засах тасаг,
9.	Хавдрын сэргээн засах оношилгоо, эмчилгээ	12	Хавдар Судлалын Үндэсний төв

### Тойролтын агуулга

#### Нэгдүгээр тойролт: Үйл ажиллагааны анатоми, биомеханик

- Хүний биеийн бүтэц: нэршил, биеийн тэнхлэг, байрлал, хөдөлгөөн, дэлхийн татах хүчний төв
- Хүний биеийн эд: хучуур эд, холбогч эд, булчин, мэдрэлийн эд
- Хүний биеийн эрхтэн тогтолцоо: яс-булчин, мэдрэл, цусны эргэлт, хоол боловсруулах, амьсгал, зүрх судас, шээс дамжуулах, дотоод шүүрэл, арьс

- Дээд мөч: мөр, бугалга, тохой, шуу, сарвууны үе, булчин, мэдрэл, хөдөлгөөн
- Доод мөч: аарцаг, түнх, өвдөг, шагай, өлмийний үе, булчин, мэдрэл, хөдөлгөөн
- Нуруу: бүтэц, үйл ажиллагаа

#### **Хоёрдугаар тойролт: Дотрын сэргээн засах оношилгоо, эмчилгээ (амьсгал, зүрх судас, настаны сэргээн засах)**

- Амьсгалын эрхтэн тогтолцооны анатоми, физиологи, патофизиологи
- Зүрх судасны эрхтэн тогтолцооны анатоми, физиологи, патофизиологи
- Амьсгалын үйл ажиллагааны сорилууд
- Амьсгал, зүрх судасны эмгэгийн үед хийгдэх сэргээн засах тусламж үйлчилгээ
- Эмчилгээний дасгал хөдөлгөөний амьсгал, зүрх судасны тогтолцоонд үзүүлэх нөлөө, ач холбогдол
- Ачаалалтай сорилууд, хийх аргууд, дүгнэлтийг эмнэлзүйд ашиглах
- Эрүүл болон эмгэг насжилт, өтлөлтийн тухай үндсэн ойлголт, гарах өөрчлөлтүүд
- Ахмад настанд тохиолдох эмгэгүүд: тархалт, патологи, насжилтын явцыг үнэлэх аргууд, эмчилгээ
- Ахмад настанд зонхилон тохиолдох эмгэгүүдийн үеийн сэргээн засах тусламж үйлчилгээ

#### **Гуравдугаар тойролт: Өвдөлтийн менежмент**

- Өвдөлтийн тухай үндсэн ойлголт, эмчилгээний аргууд
- Өвдөлтийн үед хийгдэх сэргээн засах эмчилгээний аргууд, хүндрэл
- Өвдөлтийн менежментийн заалт, эсрэг заалт, эрсдэл, ач холбогдол
- Өвчтөний сэтгэлзүйн байдалд үнэлгээ өгөх
- Нуруу, хүзүү өвдөх үеийн тусламж үйлчилгээ
- Үе, мөч өвдөх үеийн тусламж үйлчилгээ
- Булчин-хальс, фибромиалгийн үеийн тусламж үйлчилгээ
- СТ, MRI, рентген унших, цусны шинжилгээнд дүгнэлт өгөх
- Мэдрэл, яс булчингийн хэт авиан шинжилгээнд дүгнэлт өгөх

#### **Дөрөвдүгээр тойролт: Ортоз, протез, туслах технологи**

- Ортез, протезийн нэр томъёо
- Ортез, протезийн төрлүүд
- Ортез, протезийг өвчтөнд тааруулах, сонгох
- Ортез, протезийг өвчтөнд хэрэглүүлж сургах, сэргээн засах эмчилгээ
- Ортез, протезийн тухай сургалт, материал
- Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо
- Нийгмийн халамж, үйлчилгээ,
- Эрүүл мэндийн хууль
- Эмнэлгийн тусламжийн хууль

**Тавдугаар тойролт: Захын мэдрэл, яс-булчингийн хэт авиа, булчингийн цахилгаан бичлэг, уродинамик, радиологи**

- Яс-булчингийн хэт авиан оношилгоо, хэт авиан хяналтанд тарилга хийх
- Булчингийн цахилгаан бичлэгийн үндэс, арга, дүгнэлт
- Уродинамикийн шинжилгээний арга, дүгнэлт
- Радиологийн үндэс

**Зургаадугаар тойролт: Мэдрэлийн өвчний сэргээн засах оношилгоо, эмчилгээ**

- Мэдрэлийн эрхтэн тогтолцооны анатоми, бүтэц, үйл ажиллагаа
- Сэргээн засах эмчилгээний мэдрэлийн үзлэг, ялган оношилгоо
- Тархины харвалтын сэргээн засах тусламж үйлчилгээ
- Тархины гэмтлийн сэргээн засах тусламж үйлчилгээ
- Мэдрэл-булчингийн өвчний сэргээн засах эмчилгээ
- Хөдөлгөөний эмгэгийн сэргээн засах тусламж үйлчилгээ
- Захын мэдрэлийн эмгэгийн сэргээн засах тусламж үйлчилгээ
- Тархины мэс засал, хавдрын дараах сэргээн засах тусламж үйлчилгээ
- Булчин чангарлын менежмент
- Тархмал хатуурлын сэргээн засах тусламж үйлчилгээ
- Харилцах чадвар алдагдалтай хүнтэй ажиллах менежмент
- Мэдрэлийн эмгэгийн тавиланг тодорхойлох
- Мэдрэлийн эмгэгийн үед хэрэглэх эмийн бодисийн үйлчлэл, гаж нөлөө
- Тархи, нугасны CT, MRI, рентген унших, дүгнэлт өгөх

**Долоодугаар тойролт: Хүүхдийн өвчний сэргээн засах оношилгоо, эмчилгээ**

- Хүүхдийн эрхтэн тогтолцооны анатоми, бүтэц, үйл ажиллагааны онцлог
- Хүүхдийн өсөлт хөгжлийн үе шатууд
- Хүүхдийн ой ухаан, сэтгэц, биеийн хөгжлийг үнэлэх, тавиланг тодорхойлох
- Зонхилон тохиолдох хүүхдийн өвчний сэргээн засах тусламж үйлчилгээ
- Тархины саажлын сэргээн засах тусламж үйлчилгээ
- Булчин чангарлын менежмент
- Сэргээн засах эмчилгээ хийх төлөвлөгөө боловсруулах, тусламж үйлчилгээ үзүүлэх

**Наймдугаар тойролт: Гэмтлийн дараах сэргээн засах оношилгоо, эмчилгээ**

- Нугас, тулгуур эрхтэн тогтолцооны бүтэц, үйл ажиллагаа
- Нуруу, нугасны гэмтлийн дараах сэргээн засах тусламж үйлчилгээ
- ASIA ангиллаар өвчтөнд үзлэг, үнэлгээ өгөх
- Түлэгдэлт, хөдөлтийн дараах сэргээн засах тусламж үйлчилгээ
- Хугарлын дараах сэргээн засах тусламж үйлчилгээ
- Үе солиулах мэсзаслын дараах сэргээн засах тусламж үйлчилгээ

- Хөл, гар тайруулах мэс заслын дараах сэргээн засах тусламж үйлчилгээ

#### **Есдүгээр тойролт: Хавдрын сэргээн засах оношилгоо, эмчилгээ**

- Хавдрын үеийн үйл ажиллагааны чадвар алдагдал, оношилгоо
- Хавдрын эмчилгээний шалтгаант чадвар алдагдал, оношилгоо, сэргээн засах тусламж үйлчилгээ
- Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ

### **Загвар 1**

#### **Ажлын байрны сургалт (On-the-Job Training)**

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Үйлчлүүлэгч/Хэрэглэгдэхүүн	Удирдагч, хамтрагч
Амбулаторийн үзлэг хийх	1	3 цаг 7 хоногт 2 удаа	Амбулатори	Өвчтөн	Эмнэлзүйн сургагч багш
Хяналтын тойрон үзлэг хийх	3-5	1 цаг өдөр бүр	Тасаг	Өвчтөн	Эмнэлзүйн сургагч багш
Сургалтын тойрон үзлэг хийх	20 хүртэл	1 цаг 7 хоногт 1 удаа	Сургалтын өрөө, танхим	Слайд	Эмнэлзүйн сургагч багш
Гардан үйлдэл хийх	1-2	Тохиолдол байгаа үед	Амбулатори, тасаг	Өвчтөн	Эмнэлзүйн сургагч багш, бусад эмч

#### **Хяналтын тойрон үзлэг:**

Хэвтэн эмчлүүлж байгаа өвчтөний биеийн байдлыг суралцагч эмч нь эмнэлзүйн сургагч багшид (бусад эмч) танилцуулах зорилготой үзлэг хийнэ. Үүний тулд суралцагч эмч нь урьдчилан бие даан өвчний түүх, сувилагчийн тэмдэглэлийг үзэж танилцан өвчтөнтэй уулзаж, асуумж цуглуулж (ганцаарчилсан үзлэг), эмнэлзүйн сургагч багшид (бусад эмч) танилцуулахад бэлдэнэ. Танилцуулга хийхдээ хувь хүний мэдээллийг анхаарна. Танилцуулгыг сургалтын өрөө, танхим эсвэл өвчтөний өрөөнөөс гадна хийх ба өвчтөний орны дэргэдэх тойрон үзлэгийг эмнэлзүйн сургагч багштай (бусад эмч) хамт хийнэ. Хяналтын тойрон үзлэгээр өвчтөнөөс асуумж авах, үзлэг хийх аргад суралцана.

#### **Сургалтын тойрон үзлэг:**

Сургалтад тохиромжтой 1-2 өвчтөнг сонгож, өвчтөний биеийн байдлыг суралцагч эмч нь танилцуулах ба бусад оролцогчид (хамтран суралцагч эмч, эмнэлзүйн сургагч багш, бусад эмч) асуулт тавьж, хэлэлцүүлэг хийнэ. Эмнэлзүйн 1 тохиолдолд 30-60 минут зарцуулна. Үүний дараа өвчтөний орны дэргэд үзлэг хийнэ. Хэлэлцүүлгийн явцад эмнэлзүйн таамаглал дэвшүүлэх, онош тавих зэрэгт суралцана.

#### **Гардан үйлдэл хийх:**

Сургалтад тохиромжтой 1-2 өвчтөнг сонгож, суралцагч эмч нь эмнэлзүйн сургагч багш, бусад эмчийн удирдлага дор эмчилгээг гардан хийнэ. 1 өвчтөнд 30-60 минут

зарцуулна. Эмчилгээний явцад эмнэлзүйн шинж тэмдэг, эмчилгээний зарчим, хийх арга зэрэгт суралцана.

### Загвар 2

#### Танхимын сургалт (Off-the Job Training)

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Хэрэглэгдэхүүн	Удирдагч, хамтрагч
Бие даалт	1	Тохиромжтой, чөлөөт цаг	Гэртээ, номын сан	Ном, интернет	Өөрөө, хамтран суралцагч эмч
Лекц	20 хүртэл	7 хоногт 1-2 удаа 1 цаг	Сургалтын анги, танхим	Слайд	Эмнэлзүйн сургагч багш, хамтран суралцагч эмч
Журнал клуб	20 хүртэл	14 хоногт 1 удаа 2 цаг	Сургалтын анги, танхим	Слайд, эрдэм шинжилгээний өгүүлэл	Эмнэлзүйн сургагч багш, хамтран суралцагч эмч
Симуляци (дуураймал орчин)	5 хүртэл	7 хоногт 1 удаа 1 цаг	Яаралтай тусламжийн өрөө	Хамтран суралцагч эмч, манекин	Эмнэлзүйн сургагч багш

### Загвар 3

#### Үйл ажиллагааны хуваарь

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
-8:00	Ганцаарчилсан үзлэг	Ганцаарчилсан үзлэг	Ганцаарчилсан үзлэг	Ганцаарчилсан үзлэг	Ганцаарчилсан үзлэг
8:00-9:00	Хяналтын тойрон үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Хяналтын тойрон үзлэг
9:00-	Амбулаторийн үзлэг	Бие даалт	Амбулаторийн үзлэг	Бие даалт	Амбулаторийн үзлэг
12:00-13:00	Бие даалт	Лекц, семинар	Бие даалт	Лекц, семинар	Журнал клуб
16:00-17:00	Сургалтын тойрон үзлэг	Бие даалт	Сургалтын тойрон үзлэг	Бие даалт	Бие даалт

## ДОЛОО. ҮНЭЛГЭЭ, ЭРГЭН ЗӨВЛӨГӨӨ

### 7.1. Суралцагч эмч ба хариуцагч

Сургалтын 2 жилийн хугацаанд суралцагч эмч хэрхэн ахин дэвшиж байгаа, юуг сайжруулах тухай зөвлөгөө өгөх, суралцагч эмчийн хувийн төлөвлөгөөний (career plan) талаар зөвлөлдөх, тэднийг хариуцан ажиллах хүн (mentor) цаашид ("хариуцагч" гэх)-ийг хуваарилна. Суралцагч эмч нь сургалт эхлэх үед хариуцагчтай уулзах ба цаашид 2-3 сар тутамд 1 удаа уулзан ярилцаж, үнэлгээтэй танилцаж, зөвлөгөө авна.

### 7.2. Суралцагч эмч ба эмнэлзүйн сургагч багш

Суралцагч эмчийн тойролт бүрт сургалт удирдах эмнэлзүйн сургагч багшийг хуваарилна:

- Суралцагч эмч нь тухайн тойролт эхлэхээс өмнө эмнэлзүйн сургагч багштай уулзаж, тойролтын хугацаанд тавьсан зорилтоо ярилцана.

- Суралцагч эмч нь тойролтын явцад тавьсан зорилтод хүрэхийн тулд дутагдаж байгаа зүйл, түүнийг нөхөхөд хэрэгцээтэй байгаа зүйлийн тухай эмнэлзүйн сургагч багштай ярилцана.
- Суралцагч эмч нь тойролт дуусахад эмнэлзүйн сургагч багштай ярилцлага хийж, сургалттай холбоотой асуудлаар заавар, зөвлөгөө авна.

### **7.3. Үнэлгээний арга**

#### **7.3.1. Төгсөлтийн шалгалт**

Төгсөлтийн шалгалтад тэнцсэн тохиолдолд “Сэргээн засахын эмч” үндсэн мэргэшлийн эмчийн үнэмлэх олгоно.

#### **7.3.2. Сорилын шалгалтын үнэлгээ**

Тойролт бүрт үзсэн онолын мэдлэгийг тестээр шалгаж үнэлнэ. Сорил нь ганц зөв хариулттай, олон зөв хариулттай, уялдуулан сонгох, шалтгаан хамаарлын гэсэн 4 хэлбэртэй байна.

Сорилын шалгалт авах багшийг сургалтын албанаас томилно. Үнэлгээний дүнг суралцагч эмч болон хариуцагчид танилцуулж, үнэлгээнд үндэслэсэн хариуцагчаас суралцагчид зөвлөгөөг өгнө.

#### **7.3.3. Ажлын байранд суурилсан үнэлгээ**

##### **(Workplace-based Assessment) 360 хэмийн үнэлгээ (360-Degree Assessment):**

Суралцагч эмчийн мэргэжлийн байх (professionalism) болон зохион байгуулагч (organizer), манлайлагч (leader) байх зэргийг үнэлэхэд хэрэглэнэ. Ажлын байранд суурилсан үнэлгээг 2 жилийн сургалтын дунд болон төгсөх үед хийнэ. Тойролтыг удирдсан эмнэлзүйн сургагч багш, сувилахуйн мэргэжилтэн, тухайн тасаг, нэгжийн хамтран ажилласан эмч, эмнэлгийн мэргэжилтэн, өвчтөн зэрэг нийт 5 хүн тус тусдаа үнэлнэ. Үнэлгээний багийг сургалтын албанаас томилно. Багийн гишүүдийн үнэлгээний дунджаар суралцагч эмчийн нэгдсэн үнэлгээг гарган түүнд танилцуулж, зөвлөгөөг өгнө.

##### **Min-CEX/Эмнэлзүйн дасгал үнэлгээ (Mini-Clinical Evaluation Exercise):**

Зайлшгүй таньж мэдэх 23 шинж тэмдгээс тойролт бүрт 10-аас доошгүй шинж тэмдгийг тус бүр 3-аас доошгүй удаа буюу 30-аас доошгүй удаа үнэлгээ хийнэ. Өөр тойролтонд ижил шинж тэмдгээр үнэлгээ хийсэн ч болно. Жишээлбэл: мэдрэлийн тойролтод үл ашиглах хамшинж тэмдгийг оролцуулан 10 шинж тэмдгээр үнэлгээ хийсэн бол хавдрын тойролтод ч үл ашиглах хамшинж тэмдгийг оролцуулан 10 шинж тэмдгээр үнэлгээ хийж болно.

Үнэлгээ хийх эмчийг эмнэлзүйн сургагч багш эсвэл тухайн тасаг, нэгжийн туршлагатай эмч нараас суралцагч эмч өөрөө сонгох ба тухайн сонгосон эмч шууд ажиглаж, үнэлгээ хийсний дараа үр дүнг суралцагч эмчид танилцуулж, цаашид хэрхэн сайжруулах зөвлөгөө өгнө.

## **Гардан үйлдлийн үр чадварын шууд ажиглалт/DOPS (Direct Observation of Procedural Skills):**

Зайлшгүй сурах 13 гардан үйлдлийг хийж чаддаг болсныг эмнэлзүйн сургагч багш нотолж, баталгаа өгөх хүртэл давтан үнэлгээ хийнэ.

Үнэлгээ хийх эмчийг эмнэлзүйн сургагч багш эсвэл тухайн тасаг, нэгжийн туршлагатай эмч нараас суралцагч эмч өөрөө сонгох ба тухайн сонгосон эмч шууд ажиглаж, үнэлгээ хийсний дараа үр дүнг суралцагч эмчид танилцуулж, цаашид хэрхэн сайжруулах талаар зөвлөгөө өгнө.

## **Портфолио үнэлгээ (Portfolio Assessment):**

Суралцагч эмч нь сургалтын хугацаанд судалсан лекц, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний сургалтын үеэр эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа хийсэн материал зэрэг сургалттай холбоотой бусад бичиг баримтыг үр дүн болгож хадгална.

### **7.4. Үнэлгээний дүнг хянах**

- 360 хэмийн үнэлгээний дүнг сургалтын алба хяналт тавьж, хадгална. Үнэлгээний дүнг суралцагч эмч, хариуцагчид танилцуулах ба бусадтай хуваалцахгүй байхыг анхааруулна.
- Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг суралцагч өөрөө хадгална.
- Портфолиод үнэлгээ, эмнэлзүйн сургагч багштай зөвлөлдсөн асуудал, өгсөн зөвлөгөөг бичиж тэмдэглэн хадгална.
- Суралцагч эмч нь тойролт бүрийн төгсгөлд Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг сургалтын албанд хүлээлгэн өгнө.
- Сургалтын алба үнэлгээний дүнг сургалтын хяналтын зөвлөлд танилцуулах ба сургалтын төгсгөлд хариуцагчаас суралцагч эмчид зөвлөгөө өгнө.

### **7.5. Сургалтын төгсөлтийг шийдвэрлэх**

- Тойролт бүрт хийгдсэн Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг нэгтгэсний үндсэн дээр суралцагч эмчийг тухайн тойролтыг төгсгөх эсэх шийдвэрийг сургалтын хяналтын зөвлөл гаргана. Сургалтын хяналтын зөвлөл нь тойролт бүрт хийгдсэн Mini-CEX болон DOPS үнэлгээний дүн, 360 хэмийн үнэлгээний нэгдсэн дүн, суралцагчийн сургалтын ирц, зайлшгүй таньж мэдэж суралцах шинж тэмдэг, өвчний тохиолдол, гардан үйлдлийн тоог харгалзан сургалтын төгсөлтийн эцсийн шийдвэрийг гаргана. Шийдвэр гаргах шалгуур нь:
  - Зайлшгүй сургалтад оролцсон байх өдрийн тоо буюу сургалтын ирц: Хөдөлмөрийн тухай хуульд заасан цалинтай амралтын өдрийн тоо, хүндэтгэх шалтгаантай болон амралтын өдрийн тоог ирцэд хамааруулна. Амралтын өдрийн тоо нь сургалтын тойролт тус бүрийн нийт өдрийн 20%-аас хэтрэхгүй байна. Сургалтын ирц хангалтгүй бол тухайн тасарсан сургалтын өдөр, агуулгыг нөхүүлнэ.
  - Зайлшгүй таньж мэдэх шаардлагатай 23 шинж тэмдгээс 2 жилийн турш 18-аас доошгүйг оношилж, эмчлэн туршлага хуримтлуулсан байна.

Зайлшгүй туршлага хуримтлуулсан байх шаардлагатай өвчний тохиолдлын тоо нь:

- Ерөнхий сэргээн засах судлал тойролтод заагдсан өвчний бүх тохиолдлыг тус бүр 30-аас доошгүй удаа үзэж, туршлага хуримтлуулсан байна.
- Өвдөлтийн менежмент, ортез, протез, мэдрэл, хүүхдийн өвчин, гэмтэл, хавдрын сэргээн засах оношилгоо, эмчилгээ тойролт бүрт заагдсан өвчний бүх тохиолдлыг тус бүр 30-аас доошгүй удаа үзэж, туршлага хуримтлуулсан байна.
- Яс-булчингийн хэт авиа, булчингийн цахилгаан бичлэг, уродинамик, радиологийн шинжилгээ тус бүрт 30-аас доошгүй шинжилгээний өөрчлөлтөд тайлал хийж, туршлага хуримтлуулсан байна.
- Зайлшгүй суралцах 13 гардан үйлдлээс 2 жилийн турш бүгдийг нь хийн гүйцэтгэж, туршлага хуримтлуулсан байна.
- Явцын үнэлгээг сургалт хариуцсан координатор багш болон сургалт эрхлэх байгууллагын сургалтын алба зохицуулан ажиллах бөгөөд 1 ба 2-р дамжааны тойролт бүрийн үнэлгээ, тайлан хамгаалалтын дүнг нэгтгэж, 80% дээш рейтингтэй байж тооцогдоно.
- Тойролт бүрийн төгсгөлд эсвэл 2 жилийн сургалтын эцэст суралцагчийг төгсгөх боломжгүй гэсэн шийдвэр гарсан тохиолдолд шалтгаан, цаашид сургалтыг хэрхэн үргэлжлүүлэх тухай шийдвэр, зөвлөмжийг сургалтын алба болон хариуцагчаас тухайн суралцагч эмчид тайлбарлаж өгнө.

## **НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖҮҮЛЭЛТ**

### **8.1. Сургалтын хяналтын зөвлөл**

- Хяналтын зөвлөл нь сургалтын албаны мэргэжилтэн, эмнэлгийн тусламж үйлчилгээний байгууллагын дэд дарга, өвдөлтийн менежмент, ортез, протез, яс-булчингийн хэт авиа, булчингийн цахилгаан бичлэг, радиологи, мэдрэл, хүүхэд, гэмтэл, хавдрын сэргээн засах тасгийг хариуцагч, тухайн тойролтын сургалт хариуцагч, сувилахуйн алба, эмнэлгийн захиргааны алба, суралцагч эмчийн төлөөллөөс тус тус бүрдэнэ. Сургалтын хяналтын зөвлөл нь эмнэлгийн тусламж үйлчилгээний байгууллагын даргын шууд удирдлагад ажиллана.
- Сургалтын хяналтын зөвлөл улиралд нэг удаа хуралдана.
- Сургалтын хяналтын зөвлөл нь суралцагч эмчийн сургалт, тулгарсан асуудалтай танилцах, суралцагч эмчтэй холбоотой бүх асуудлыг ярилцаж, шийдвэрлэх арга замыг тодорхойлно.
- Сургалтын хяналтын зөвлөлийн гишүүд сургалтыг илүү сайжруулахын тулд өөрийн мэдлэг, боловсролоо дээшлүүлэхийг зорьж ажиллана.

### **8.2. Хөтөлбөрийн хяналт**

- Сургалтын алба хөтөлбөрт улирал бүр хяналт тавина.
- Энэхүү хөтөлбөрийг 5 жил тутамд үнэлнэ.

- Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын төлөвлөгөө гаргах, эмнээүйн сургагч багшид чиглэсэн сургалт (Faculty Development), суралцагч эмчийн нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх, шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгах зэргийг сургалтын алба хариуцна.
- Хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд сургалтын хяналтын зөвлөлөөр хэлэлцүүлэн өөрчлөлт оруулна. Энэ тухай Эрүүл мэндийн хөгжлийн төвд албан бичгээр ажлын 10 хоногт багтаан мэдэгдэнэ.

### 8.3. Сургалтын танилцуулга (Orientation)

Сургалт эхлэхийн өмнө тойролт бүрийн сургалтын төлөвлөгөө (Training plan) болон хөтөлбөрийн (Curriculum) агуулгын уялдааг тодорхой ойлгох, сургалт эрхлэх байгууллага (эмнэлэг, эрүүл мэндийн төв), түүний үйл ажиллагаа, эмчилгээ, оношилгооны аюулгүй байдал, халдвар хамгааллын тухай суралцагч эмчид тодорхой ойлголт өгөх зорилго бүхий танилцуулга хичээлийг зохион байгуулна.

Хавсралт 1

### ДАДЛАГА ШАЛГАЛТЫН ХУУДАС

Суралцагч эмч: .....ОВОГ .....нэр

Рез 1  Рез 2

№	Үнэлгээний шалгуур	%	Рейтинг оноо, %		
			Багш 1	Багш 2	Багш 3
1	Өвчтөнөөс зовуурь, өгүүлэмж цуглуулах	10%			
2	Өвчтөнтэй харилцах ур чадвар, хандлага	10%			
3	Сэргээн засах эмчийн үзлэг хийх ур чадвар	20%			
4	Үйл ажиллагааны онош тавих чадвар	10%			
6	Эмнэлзүйн онош тавих	10%			
7	Ойрын ба алсын төлөвлөгөө гаргах	10%			
8	Оновчтой эмчилгээний төлөвлөгөө гаргах чадвар	20%			
9	Зөвлөгөө өгөх чадвар	10%			
Нийлбэр үнэлгээ		100%			

Багшийн гарын үсэг:

1. \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /  
 2. \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /  
 3. \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

Он, сар, өдөр \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ / \_\_\_\_\_

Хавсралт 2

### ШАЛГАЛТЫН ХУУДАС

Шалгалтын төрөл:  Явцын  Төгсөлтийн

Суралцагч эмч: .....ОВОГ .....нэр;

Рез 1  Рез 2

№	Үзүүлэлт	Рейтинг оноо, %	Үсгэн үнэлгээ
1	Онолын мэдлэгийн үнэлгээ (сорилын шалгалт, 80-с дээш)		
2	Эмнэлзүйн дадлага шалгалт - Гардан үйлдэл хийх чадвар (80-с дээш)		

Дундаж үнэлгээ		
----------------	--	--

**Тайлбар:** Суралцагчийн мэдлэг, ур чадварыг үсэг, рейтинг үнэлгээ зэргээр үнэлнэ.  
90-100 – А 80-89 – В 70-79 – С

Шалгалтын комисс: 1. ....  
2. ....  
3. ....  
4. ....  
5. ....

Хавсралт 3

### 360 ХЭМИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Суралцагч эмчийн нэр: \_\_\_\_\_  Рез 1  Рез 2

Тухайн жилийн үнэлгээний дугаар:  1  2  3  4 Он, сар, өдөр  
\_\_\_\_/\_\_\_\_/\_\_\_\_/

Үнэлэгч:  Эмнэл зүйн сургагч багш  Сувилагч  Бусад \_\_\_\_\_

Суралцагч эмчийг ажигласны үндсэн дээр, бусдаас сонссон, мэдсэн зүйл дээр бус, суралцагч эмчийн зан үйлийг хэр давтамжтай байсныг өөрийнхөө ажигласанаар оноо тавина уу.

<input type="checkbox"/> ҮБ	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Үнэлэх боломжгүй	Ховор (≤19%)	Заримдаа (20-49%)	Ихэнхдээ (50-79%)	Бараг бүгд (≥80%)
Өвчтөн, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, бусад суралцагч эмч нартай хүндэтгэлтэй харьцаж чаддаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3 <input type="checkbox"/> 4
Эмнэлгийн бичиг баримтыг бүрэн гүйцэд, гаргацтай, цаг хугацаанд нь хөтөлдөг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3 <input type="checkbox"/> 4
Өвчтөнд тохирсон оношилгоо, эмчилгээ, сувилгааны хамгийн зөв шийдвэрийг гаргахыг хичээн зүтгэл гаргадаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3 <input type="checkbox"/> 4
Өвчтөн, эмнэлгийн мэргэжилтнүүдтэй үр дүнтэй харилцаа үүсгэж чаддаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3 <input type="checkbox"/> 4
Үйлчлүүлэгч, хувь хүний нууцыг хадгалж чаддаг	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3 <input type="checkbox"/> 4
Өөрийн эмнэлзүйн ур чадварыг дээшлүүлэхийн тулд сургалт болон бусад боломжийг алдалгүй ашигладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3 <input type="checkbox"/> 4
Өөрийн анагаах ухааны онолын мэдлэгээ дээшлүүлэхийн тулд бие даан суралцдаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3 <input type="checkbox"/> 4
Суралцагч эмч нь сайн сонсогч байж чаддаг	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3 <input type="checkbox"/> 4
Эмч, мэргэжилтэнтэй хамтран багаар ажилладаг	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3 <input type="checkbox"/> 4
Суралцагч эмч нь бусдад суралцахад нь тусалдаг	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3 <input type="checkbox"/> 4
Суралцагч эмч нь эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг эрхэмлэн ажилладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3 <input type="checkbox"/> 4
Өвчтөн, хамтран ажиллагсдын зан араншин, сэтгэл хөдлөл, нас, хүйс, соёл, тахир дутуу зэрэг нөхцлийг мэдрэмжтэй, зөв үнэлж чаддаг	<input type="checkbox"/> NAN <input type="checkbox"/> ANA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3 <input type="checkbox"/> 4

Өвчтөн, түүний ар гэрт сайн зөвлөгч байж чаддаг	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
---	-----------------------------	----------------------------	----------------------------	----------------------------	----------------------------

**Дүгнэлт:**

Суралцагч эмчийн амжилттай гүйцэтгэсэн үйлдлийг нэрлэнэ үү (1-2):
Суралцагч эмчийн цаашид сайжруулах үйлдлийг нэрлэнэ үү (2-3):
Суралцагч эмчийн онцгой анхаарах үйлдлийг нэрлэнэ үү:
Суралцагч эмчийн гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээ

Хавсралт 4

**ЯВЦЫН MINI-СЕХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Сургагч багшийн нэр: \_\_\_\_\_ Он, сар, өдөр \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /  
 Суралцагч эмчийн нэр: \_\_\_\_\_ Рез 1  Рез 2   
 Үнэлгээ хийгдсэн тасаг/ нэгж: \_\_\_\_\_

Тухайн жилийн үнэлгээний дугаар:  1  2  3  4

Өвчтөн: \_\_\_\_\_ нас \_\_\_\_\_ хүйс  Эр  Эм Регистрийн дугаар \_\_\_\_\_

Үнэлгээний төрөл:  Анхан  Давтан Тохиолдлын зэрэг:  Хөнгөн  Дунд  Хүнд

Үнэлгээний зорилго:  Судалгаа  Оношилгоо  Эмчилгээ  Зөвлөгөө

Өвчтөний зовуурь: \_\_\_\_\_  
 \_\_\_\_\_  
 \_\_\_\_\_  
 \_\_\_\_\_  
 \_\_\_\_\_  
 \_\_\_\_\_

Сургалтын тухайн үед суралцагч эмчийг ямар түвшинд байгааг ажигласнаа үнэлнэ үү.										
<b>Бодит үзлэг хийх шаардлагагүй тохиолдолд тэмдэглэнэ үү: X</b>										
№	Үнэлгээ	Хангалтгүй			Сайжруулах			Хангалттай		
		1	2	3	4	5	6	7	8	9
1	Өвчтөнөөс зовуурь, өгүүлэмж цуглуулах									
2	Өвчтөнтэй харилцах ур чадвар, хандлага									
3	Сэргээн засахын үзлэг хийх ур чадвар									
4	Оношлох, ялган оношлох ур чадвар									
5	Шинжилгээ, эмчилгээ төлөвлөх ур чадвар									
6	Зөвлөгөө өгөх ур чадвар									
7	Эмнэлзүйн ерөнхий чадвар									

Суралцагч эмчийн үйлдлийн сайн талууд:
Суралцагч эмчийн үйлдэлд сайжруулахад чиглэсэн зөвлөгөө:
Суралцагч эмчийн гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээ:

MINI-CEX үнэлгээ хийсэн хугацаа: \_\_\_\_\_ /мин/. Зөвлөгөө өгсөн хугацаа \_\_\_\_\_ /мин/

MINI-CEX үнэлгээ хийсэн багшийн сэтгэл ханамж:

Бага 1 2 3 4 5 6 7 8 9 Их

MINI-CEX-р үнэлүүлсэн суралцагч эмчийн сэтгэл ханамж:

Бага 1 2 3 4 5 6 7 8 9 Их

Багшийн гарын үсэг: \_\_\_\_\_ Суралцагч эмчийн гарын үсэг \_\_\_\_\_

Санамж:

<b>“Хангалттай” гэж тодорхойлоход хэрэглэгдэх үзүүлэлт</b>	
<b>Өвчтөнөөс зовуурь, өгүүлэмж цуглуулах</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Өвчтөний зовуурийг нэг бүрчлэн илрүүлж эрэмблэж чаддаг</li> <li>• Зовуурь бүрийн эхлэл, явц, өөрчлөлт, нөлөөлсөн хүчин зүйлийг тодруулж асуудаг</li> <li>• Ялган оношилгоо хийхүйц дэлгэрэнгүй асуумж авдаг</li> <li>• Өвчтөний бусад хэрэгцээг илрүүлж, хариу үзүүлдэг</li> <li>• Өвчтөний дохио зангааг ойлгож, тохиромжтой хариу үзүүлдэг</li> </ul>
<b>Сэргээн засахын үзлэг хийх ур чадвар</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Сэргээн засахын үзлэгийг өвчтөнд тохируулан оновчтой үзэх чадвар эзэмшсэн</li> <li>• Ялган оношилгоо хийхүйц дэс дараалсан дэлгэрэнгүй бодит үзлэг хийдэг.</li> <li>• Үзлэгийн үед өвчтөнд таатай байдал бүрдүүлэхэд анхаардаг</li> </ul>
<b>Өвчтөнтэй харилцах ур чадвар, хандлага</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл, садны хүнийг сайн сонсдог</li> <li>• Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл, садны хүний зовнилыг хуваалцаж, хүндэтгэлтэй ханддаг</li> <li>• Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл, садны хүнтэй зөв, энгийн үг хэллэг хэрэглэж харилцдаг</li> </ul>
<b>Оношлох, ялган оношлох ур чадвар</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Илэрсэн шинж тэмдэг, зовуурьт онолын зөв тайлбар өгч чаддаг</li> <li>• Үйл ажиллагааны зөв онош тавьдаг</li> <li>• Эмнэлзүйн зөв онош тавьдаг</li> <li>• Өвчний ялган оношилгоог хийдэг</li> </ul>
<b>Шинжилгээ, эмчилгээ төлөвлөх ур чадвар</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Шаардлагатай шинжилгээг төлөвлөж чаддаг, төлөвлөсөн шинжилгээний зорилго, хүлээгдэж байгаа үр дүнг тайлбарлаж чаддаг</li> <li>• Хийгдсэн шинжилгээний үр дүнг ашигладаг</li> <li>• Тохирсон эмчилгээг төлөвлөдөг, эхлүүлдэг</li> <li>• Хэрэглэж байгаа эм, тарианы тун, хэлбэр, хэмжээ, заалт, эсрэг заалт, гаж нөлөөг мэддэг</li> <li>• Тохирсон тасаг, эмнэлэгт шилжүүлэх заалтыг мэддэг</li> </ul>
<b>Зөвлөгөө өгөх ур чадвар</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагчид тухайн өвчний талаар дэлгэрэнгүй тайлбарлаж зөвлөгөө өгдөг</li> <li>• Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагчид өвчин, түүнээс урьдчилан сэргийлэх аргын талаар зөвлөгөө өгдөг</li> <li>• Асуултанд дэлгэрэнгүй, энгийн үг хэллэг хэрэглэж тайлбарладаг</li> </ul>
<b>Эмнэлзүйн ерөнхий чадвар</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Цогц, дэс дараатай, харилцан уялдаатай үзлэг хийж чаддаг</li> <li>• Зовуурь, шинж тэмдэг, эмгэг жамын шалтгаан хамаарлыг тогтоохыг эрмэлздэг</li> <li>• Өвчтөнд зөв онош, эмчилгээ хийхийг чармайдаг</li> <li>• Өвчтөнд итгэл төрүүлэхүйц таатай харьцаа, аюулгүй байдлыг хангахад тодорхой идэвхи зүтгэл гаргадаг</li> </ul>

**ГАРДАН ҮЙЛДЛИЙН УР ЧАДВАРЫН ШУУД АЖИГЛАЛТ  
(DOPS)-ЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Сургагч багшийн нэр: \_\_\_\_\_ Он, сар, өдөр \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

Суралцагч эмчийн нэр: \_\_\_\_\_  R1  R2

Үнэлгээ хийгдсэн тасаг: \_\_\_\_\_

Тухайн жилийн үнэлгээний дугаар:  1  2  3  4

Өвчтөн: \_\_\_\_\_ нас \_\_\_\_\_ хүйс  Эр  Эм Регистрийн дугаар \_\_\_\_\_

Үнэлгээний төрөл:  Анхан  Давтан  Төлөвлөгөөт  Яаралтай   
Хойшлуулашгүй

Гардан үйлдлийн зэрэг:  Хөнгөн  Дунд  Хүнд  
Үнэлгээний зорилго:  Судалгаа  Оношилгоо  Эмчилгээ  Бусад

Гардан үйлдэл:  Үений хөдөлгөөний далайц үнэлэх  Булчингийн хүч үнэлэх   
 Өвдөлтийг үнэлэх  Биеийн ачаалал даах чадварыг тодорхойлох  Өдөр тутмын үйл  
ажиллагааг үнэлэх  Морфометрийн үнэлгээ хийх  Булчингийн тонус шалгах   
 Рефлекс үнэлэх  Мэдрэхүйг үнэлэх  Тэнцвэрийг үнэлэх  Төрх байдлыг үнэлэх   
 Алхааны үнэлгээ хийх  Өвөрмөц сорилуудаар үнэлэх

Өнөөг хүртэл суралцагч эмчийн тухайн гардан үйлдлийг хийсэн тоо

\_\_\_\_\_

Сургалтын тухайн үед суралцагч эмчийг ямар түвшинд байгааг ажигласнаа үнэлнэ үү. Үнэлгээ хийх шаардлагагүй тохиолдолд тэмдэглэнэ үү: X											
№	Шалгуур	Хангалтгүй			Сайжруулах			Хангалттай			Үнэлгээ шаардлагагүй
		1	2	3	4	5	6	7	8	9	
1	Хийх гэж буй үйлдлийн заалт, эсрэг заалт, анатоми, үйлдлийг хийх аргачлалыг бүрэн ойлгож мэддэг										
2	Хийх гэж буй үйлдлээ өвчтөнд тайлбарладаг /өвчтөнөөс зөвшөөрлийн хуудас авдаг										
3	Гардан үйлдэл хийх бэлтгэлийг зохистой хангадаг, үйлдлийн өмнөх нөхцлийг зөв үнэлдэг										
4	Өвчтөний аюулгүй байдлыг хангадаг										
5	Ариун материалтай зөв харьцдаг, халдваргүйжүүлэх										

	үйлдлийг зөв гүйцэтгэдэг, багаж хэрэгслийг аюулгүй хэрэглэдэг								
6	Гардан үйлдлийг арга техникийг бүрэн эзэмшиж чадварлаг гүйцэтгэдэг								
7	Гардан үйлдэл амжилтгүй байгааг ойлгож, шаардлагатай үед тусламж дууддаг								
8	Үйлдлийн дараах менежментийг зохистой хангадаг								
9	Үйлдлийн үеийн харилцааны ур чадвар, хандлага								
10	Үйлдлийн эмх цэгцийг хангадаг								
11	Шаардлагатай бичиг баримтыг бүрэн гүйцэд гаргацтай цаг хугацаанд хөтөлдөг								
13	Гардан үйлдэл хийх ерөнхий ур чадвар								

**Зөвлөмж:**

Суралцагч эмчийн үйлдлийн сайн талууд:

-----  
 -----  
 -----  
 -----

Суралцагч эмчийн үйлдэлд сайжруулахад чиглэсэн зөвлөгөө:

-----  
 -----  
 -----  
 -----

Суралцагч эмчид өгөх эцсийн санал (нэгийг сонгох):

- Үйлдлийг гүйцэтгэх мэдлэг, чадвар хангалтгүй
- Сургагч багшийн хяналтанд үйлдлийг хийх /хянах түвшинг сургагч багш шийдвэрлэнэ/
- Суралцагч эмч үйлдлийг бие даан хийх боломжтой
- Суралцагч эмч энэхүү үйлдлийг бусдад заах/бусдыг хянах боломжтой

Суралцагч эмчид өгөх **БУСАД** санал:

-----  
 -----

DOPS үнэлгээ хийсэн хугацаа: \_\_\_\_\_ /мин/. Зөвлөгөө өгсөн хугацаа \_\_\_\_\_ /мин/

**DOPS** үнэлгээ хийсэн **БАГШИЙН** сэтгэл ханамж:

Бага 1 2 3 4 5 6 7 8 9 Их

**DOPS** -р үнэлүүлсэн **СУРАЛЦАГЧ ЭМЧИЙН** сэтгэл ханамж:

Бага 1 2 3 4 5 6 7 8 9 Их

Багшийн гарын үсэг: \_\_\_\_\_ Суралцагч эмчийн гарын үсэг \_\_\_\_\_

---

Санамж:

Хийх гэж буй үйлдлийн заалт, эсрэг заалт, анатоми, үйлдлийг хийх аргачлалыг бүрэн ойлгож мэдэх	<ul style="list-style-type: none"> <li>• Сургагч багшид үйлдлийн заалт, эсрэг заалт, холбогдох морфологи анатомийн бүтэц, үйлдлийн үе шат, үйлдлийг гүйцэтгэх аргачлал, хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийн заалт, эсрэг заалт, гаж нөлөө, болзошгүй эрсдэл, хүндрэлийн үеийн яаралтай тусламжийн талаар мэдлэгтэй, бүрэн тайлбарлаж чаддаг.</li> </ul>
Хийх гэж буй үйлдлээ өвчтөнд тайлбарладаг, өвчтөнөөс зөвшөөрөл /зөвшөөрлийн хуудас авах	<ul style="list-style-type: none"> <li>• Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагчид үйлдлийн талаар бүрэн гүйцэд, дэлгэрэнгүй, ойлгомжтой, энгийн үг хэллэг ашиглан зохих тайлбарыг өгдөг.</li> <li>• Өвчтөн үйлдлээс айсан, сэтгэл нь тогтворгүй, түгшсэн тохиолдолд зовнилыг ойлгож, хуваалцаж, хүндэтгэлтэй, тэвчээртэй ханддаг, сонирхсон асуултанд оновчтой хариулдаг.</li> <li>• Зөвшөөрлийн хуудас бөглөхөөс өмнө өвчтөн нь гардан үйлдлийн талаар зохих ойлголттой байгаа талаар нягталдаг.</li> <li>• Өвчтөнд итгэл, үнэмшил төрүүлдэг.</li> <li>• Өвчтөнөөс шаардлагатай ажилбарт зөвшөөрлийн хуудас бөглүүлдэг.</li> </ul>
Гардан үйлдэл хийх бэлтгэлийг зохистой хангадаг, үйлдлийн өмнөх нөхцлийг зөв үнэлэх	<ul style="list-style-type: none"> <li>• Гардан үйлдлийг гүйцэтгэх төлөвлөгөөтэй.</li> <li>• Өвчтөний сэтгэл санаа, тайван байдлыг хангадаг.</li> <li>• Үйлдлийг гүйцэтгэхэд шаардлагатай үндсэн болон нэмэлт тоног төхөөрөмж, эд зүйлсийг бэлтгэдэг.</li> <li>• Ажилбарын өмнөх хяналтын хуудас бөглөдөг, ажилбарын явц болон ажилбарын дараахь хяналтын хуудас, бичиг баримтыг бэлтгэдэг.</li> <li>• Гардан үйлдэлд шаардлагатай хувцас, өмсгөлийг бэлтгэдэг.</li> <li>• Үйлдлийг гүйцэтгэхэд найрсаг, ээлтэй, дулаан, байгалийн гэрэлтэй, цэвэр орчин бүрдүүлдэг.</li> </ul>
Өвчтөний аюулгүй байдлыг хангах	<ul style="list-style-type: none"> <li>• Гардан үйлдэл хийгдэх өвчтөний овог, нэр, регистрийн дугаар болон бусад аргуудаар танин тодруулдаг.</li> <li>• Үйлдлийг гүйцэтгэхэд хэрэглэх/хэрэглэж болзошгүй тайвшруулах, мэдээ алдуулах эм, тарианы нэр, тун, хэрэглэх арга зэрэг чанар, аюулгүй байдлыг хангадаг.</li> <li>• Үйлдлийг гүйцэтгэхэд зөв зүү, тариурыг сонгож нягталдаг, чанар, аюулгүй байдлыг хангадаг.</li> </ul>
Ариун материалтай зөв харьцдаг, халдваргүйжүүлэх үйлдлийг зөв гүйцэтгэдэг, багаж хэрэгслийг аюулгүй хэрэглэх	<ul style="list-style-type: none"> <li>• Ариун бээлийг зөв задалж өмсөж, тайлдаг.</li> <li>• Ариун салфетка, ариун хөвөн бөмбөлөг, нэг удаагийн зүү, тариуртай зөв харьцдаг.</li> <li>• Үйлдлийг гүйцэтгэхэд шаардлагатай халдваргүйжүүлэх уусмалыг зөв ашигладаг.</li> <li>• Үйлдлийн талбайг зөв ариутгадаг.</li> <li>• Хурц үзүүртэй зүү, эмнэлгийн хэрэгслийг зөв ашиглаж устгадаг.</li> </ul>
Гардан үйлдлийн арга техникийг бүрэн эзэмшиж чадварлаг гүйцэтгэх	<ul style="list-style-type: none"> <li>• Гардан үйлдлийн стандарт, протоколыг чанд мөрддөг.</li> <li>• Гардан үйлдлийг өөртөө итгэлтэй, чадварлаг гүйцэтгэдэг.</li> <li>• Зааварчилгааг тод, чанга дуугаар, ойлгомжтой өгдөг.</li> <li>• Зүү, тариур, тоног төхөөрөмжийг чадамгай ашигладаг.</li> <li>• Цус алдах болон бусад эрсдлээс сэргийлдэг.</li> </ul>
Гардан үйлдэл амжилтгүй байгааг ойлгож, шаардлагатай үед тусламж дуудах	<ul style="list-style-type: none"> <li>• Үйлдэл амжилтгүй байгааг өвчтөн, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сандарч тэвдэлгүй, зөв зохистой ойлгуулж мэдээлдэг.</li> <li>• Үйлдэл амжилтгүй гүйцэтгэсэнээ хүлээн зөвшөөрдөг.</li> <li>• Өвчтөн болон ажилчидтай тайван, зохистой харьцдаг.</li> <li>• Гардан үйлдлийг илүү сайн гүйцэтгэхэд бусдын тусламжийг хүсэж чаддаг.</li> <li>• Цаашид илүү амжилттай суралцах шаардлагатайг ухамсарладаг.</li> </ul>
Үйлдлийн дараах менежментийг зохистой хангах	<ul style="list-style-type: none"> <li>• Суралцагч эмч нь гүйцэтгэсэн гардан үйлдэлд бодит үнэлгээ дүгнэлтийг өгч чаддаг.</li> <li>• Үйлдлийн дараахь эмчилгээ, асаргаа сувилгаа, халдвар хяналтын зөвлөмжийг өвчтөн болон эмнэлгийн ажилчдад амаар болон бичгээр</li> </ul>

## НОМ ЗҮЙ

1. Балжинням А. Сэргээн засах судлал. Эмч, оюутан нарт зориулсан сурах бичиг. 2015 он
2. Baljinnyam A. Rehabilitation Medicine Manual. 2006
3. Braddom Randal.L. Physical Medicine and Rehabilitation. 2016.
4. Delisa. Joel A. Rehabilitation Medicine. Principles & Practice. Fifth edition. 2021.
  5. Walter R.Frontera, Julie K.Silver, Thomas D.Rizzo. Essentials of Physical Medicine and Rehabilitation. Musculoskeletal Disorders, Pain, and Rehabilitation. Third edition. 2015
  6. Tyng-Guye Wang, Wen-Shiang Chen. Musculoskeletal Ultrasound Examination. 2014
  7. Dimitru. Electrodiagnostic study, 2018
8. Lynn N.McKinnis. Fundamentals of Musculoskeletal Imaging. Fourth edition. 2014
9. Michael A.Alexander., Dennis J.Matthews. Pediatric Rehabilitation. Principles and Practice. Fifth edition, 2015.
10. Maria Stokes. Physical Management in Neurological Rehabilitation. 2004.
11. Arnold J.Capute., Pasquale J.Accorda., Eileen P.G.Vining., James E.Rubenstein., Susan Harryman. Primitive reflex profile.
12. Mohammad Agha MD, Douglas Murphy MD, Guide to Musculoskeletal Injections with Ultrasound. A Practical Handbook. 2015.
13. Peter Resteghini, Diagnostic Musculoskeletal Ultrasound and Guided Injection A Practical Guide. 2017.
14. European society of musculoskeletal radiology. Musculoskeletal ultrasound technical guidelines. 2004.
15. Jose Antonio Bouffard., Ami Mac et all.,Musculoskeletal ultrasound pocket guide. Sonographic Evaluation. 2016.
16. Levent Özçakar, FatihTok, Martine De Muynck, Vanderstraeten et all Musculoskeletal ultrasonography in physical and rehabilitation medicine. Journal of Rehabilitation Medicine 2012.
17. Stephanie Saunders., Steve Longworth et all., Injection techniques in Orthopaedics and Sports Medicine. 2006.
18. ZbigniewCzyrny., Standards for musculoskeletal ultrasound. J Ultrason 2017Donatelli Wooden. Orthopaedic Physical Therapy. 2011.
19. Susan J.Garrison. Handbook of Physical Medicine and Rehabilitation Basics. 2005.
20. William E.Prentice. Rehabilitation techniques in Sports Medicine. 2010.
21. Susan L.Michlovitz, James W.Bellew, Thomas P.Nolan Jr. Modalities for therapeutic intervention. Sixth edition. 2016.
22. А.Эрдэнэбилэг, О.Батсүх, Л.Наранбат, Х.Баттулга, Н.Отгонсайхан, Б.Золбаяр. Гэмтэл согог судлал. 2017
23. Р. Шагдарсүрэн, Ж.Олзбай, Ш.Нансалмаа. Гэмтэл согог судлал. Боть I, II. Төгсөлтийн дараах сургалтанд сурах эмч, мэргэжилтэн нарт зориулсан сурах бичиг. 2015
24. Kenneth Egol, Koval, Zuckerman. Handbook of Fractures. 2005
25. David J.Magee. Orthopedic Physical Assessment. Sixth edition. 2014
26. Jon C, Thompson. Netter`s Concise Atlas of Orthopaedic Anatomy. 2008

27. Timothy O White, Samuel P Mackenzie, Alasdair J Gray. Orthopaedic trauma, Third edition. 2018.
28. Rahij Anwar, Kenneth Turson, Shah Alam Khan. Classification and Diagnosis in Orthopaedic Trauma. 2017
29. S.Terry Canale, James H.Beaty, Frederick M Azar. Campbell`s Core orthopaedic procedures. 2016.
30. Michael A.Alexander., Dennis J.Matthews. Pediatric Rehabilitation. Principles and Practice. Fifth edition, 2015.
31. Maria Stokes. Physical Management in Neurological Rehabilitation. 2004.
32. Silvia Rodger, Jenny Ziviani. Occupational therapy with Children. Understanding children`s occupation & enabling participation. 2006
33. Kathy Fleming Drehobli., Mary Gengler Fuhr. Pediatric Massage. For the Child with Special Needs. 1991.
34. David B.Jenkens. Hollinshead`s Functional Anatomy of the Limbs and Back. 2015
35. David B.Jenkens. Холленсхэдийн мөчдийн үйл ажиллагааны анатоми. 2019
36. Stanley Hoppenfield. Physical Examination of the Spine and Extremities. 2010
37. Donatelli Wooden. Orthopaedic Physical Therapy. 2011.
38. Susan B.O`Sullivan, Thomas J.Schmitz, George D.Fulk. Physical Rehabilitation. 2019
39. Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн тусламжийн хууль, Сэргээн засах тусламж үйлчилгээний үзүүлэх журам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
40. Сэтгүүлүүд
  - Journal Rehabilitation Medicine
  - Stroke
  - Journal Neurorehabilitaion & Neurorepear
  - Journal of Neurological Rehabilitation
  - Prosthetics & Orthotics International